

ДААТГАЛЫН МЭДЭЭ

11 ДҮГЭЭР САР

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын компаниудын 2009 оны 3 дугаар сараас 11 дүгээр сар хүртэлх даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг харуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V	2009-VI	2009-VII	2009-VIII	2009-IX	2009-X	2009-XI
1	Даатгалын нийт хураамж	1 508,10	2 843,70	1 782,80	2 838,80	1 853,90	2 148,00	1 687,80	1 598,50	1 178,1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	403,90	417,40	439,70	411,50	605,90	365,00	494,00	392,80	813,1
3	Давхар даатгалд төлсөн хураамж	638,50	543,30	3 864,30	182,20	33,70	785,30	755,70	613,20	217,6
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	13 586	39 878	16 684	12 321	7 779	4 689	4 708	5 201	4 347
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	63 747,10	45 803,80	7 425,60	24 565,00	99 370,10	3 142,30	7 140,00	18 000,00	5 500,0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	95,60	50,00	46,80	21,20	101,80	45,00	70,40	43,30	250,0

2009 оны 11 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого 10 дугаар сарынхаас 26,3 хувиар буурсан бол олгосон нөхөн төлбөр 2,07 дахин нэмэгдсэн байна. Даатгалын нөхөн төлбөр ийнхүү нэмэгдэж байгаа нь замын халтиргаа ихсэж авто тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөр нэмэгдэж байгаатай холбоотой байна. Даатгалын хураамжийн орлого 4 дүгээр сард хамгийн өндөр дүнтэй байгаа бол 11 дүгээр сард хамгийн бага дүнтэй байна. Харин даатгалын нөхөн төлбөрийн дүн 10 дугаар сард хамгийн бага байсан бол 11 дүгээр сард хамгийн өндөр байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа





Ердийн даатгалын компаниудаас 2009 оны 11 дүгээр сард олгосон нөхөн төлбөрүүдээс хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Вагнер ази тоног төхөөрөмж” ХХК-ийн Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгалын гэрээний нөхөн төлбөрт 250.0 сая төгрөг олгосон байна. Уг нөхөн төлбөр нь 2009 оны 3 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл ердийн даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөрүүдээс мөн адил хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр нь байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V	2009-VI	2009-VII	2009-VIII	2009-IX	2009-X	2009-XI
1	Даатгалын нийт хураамж	1,4	4,5	1,1	1,6	0,5	3,6	5,3	11,1	71,4
2	Олгосон нийт нөхөн төлбөр	0,6	0,0	0,0	0,3	0,5	0,8	0,6	1,0	0,7
3	Давхар даатгалд төлсөн хураамж	0,0	0,0	0,0	0,0	0,0	3,8	0,0	3,8	0,0
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэгээр/	5 гэрээ	3 гэрээ	6 гэрээ	4 гэрээ	12 гэрээ	8 гэрээ	9 гэрээ	19 гэрээ	3 гэрээ
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	50,0	50,0	51,0	50,0	15,0	100,0	30,0	20,0	30,0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	0,4	0,0	0,0	0,2	0,5	0,5	0,5	1,0	0,4



“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлогыг 3 дугаар сараас 11 дүгээр сарын байдлаар авч үзэхэд 11 дүгээр сард даатгалын хураамжийн орлого 10 дугаар сарынхаас 6.4 дахин өссөн буюу 2009 оны хувьд хамгийн өндөр даатгалын хураамжийн орлогыг 11 дүгээр сард төвлөрүүлсэн байна. Харин олгосон нөхөн төлбөр 10 дугаар сарынхаас 38.6 хувиар буурсан байна.

11 дүгээр сард “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ 1, “Байгууллагын хугацаат амьдралын даатгал”-ын 2 гэрээгээр 779 хүнийг, нийт 780 хүнийг даатгалд хамруулж ажилласан байна. Гэнэтийн осол, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 714.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгожээ.